



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2018.01.24 № 06

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
САЙД УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ
ТАНАА

Асуулга тавих тухай

2018 он гарснаас хойшхи 20 гаруй хоногийн хугацаанд шатахуун, түлшний жижиглэнгийн үнэ нэмэгдэж, нийлүүлэлтийн хомсдолтой байдлаас шалтгаалан ард, иргэдийн дунд бухимдал газар авч байна. Шатахуун импортлогч компаниуд гадаад зах зээлийн үнэ нэмэгдсэн, онцгой албан татварын хувь нэмжээ нэмэгдсэн шалтгаанаар зарим төрлийн шатахууны литр тутмын жижиглэнгийн үнийг нэмэгдүүлж, нийлүүлэлтээ багасгаж, дараалал үүсгэн зах зээл дээр зохиомол хомсдол бий болгоод байна.

Уламжлалт Сар шинийн баяр болох гэж байгаатай холбогдуулан шатахууны үнэ нэмэгдсэн гэх шалтгаанаар өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ ч нэмэгдэх хандлагатай байгаа нь иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлөх нөхцлийг бүрдүүлэхээр байна.

Иймд шатахууны үнэ нэмэгдсэн болон нийлүүлэлтийн хомсдол үүссэн цаг үеийн байдалтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасны дагуу бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуулгыг Танд хандан тавьж байна. Үүнд:

1. Шатахуун, түлшийн үнэ нэмэгдэж, зохиомол хомсдол үүсэж байгаатай холбогдуулан шатахуун түлшний хомсдолыг арилгах, үнийг тогтвортой байлгах талаар ойрын үед Монгол Улсын Засгийн газрын зүгээс ямар арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа,
2. Өнөөдөр үүсээд байгаа газрын тосны бүтээгдэхүүний хомсдол, үнэ нэмж байгаа гадаад болон дотоод хүчин зүйлийн талаар хийсэн бодит судалгаа, дүгнэлт гаргасан эсэх тайлбар өгөх, татвар, үнийн бодлогоор болон эрсдлийн сан үүсгэж зохицуулах боломжтой эсэх,
3. Дотоодын хэрэглээний суурь үнэд голлон нөлөөлдөг стратегийн ач холбогдол бүхий шатахуун, түлшний хангалт, импортын байдал, зах зээлийн нийлүүлэлтийн талаар цаашид баримтлах Засгийн газрын бодлогыг танилцуулах,
4. Улсын хэмжээнд шатахуун, түлшний нөөц өнөөдөр ямар түвшинд байгаа болон цаашид нөөцийг нэмэгдүүлэх талаар ямар тодорхой арга хэмжээ авах, улсын мэдлийн газрын тосны бүтээгдэхүүний агуулах хэд байгаа, цаашид хүчин чадлыг нь хэрхэн нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа,


5. Шатахуун, түлшний үнэ нэмэгдсэн гэх шалтгаанаар өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ иргэдийн амьжиргаанд хэрхэн сөргөөр нөлөөлөх тооцооллыг танилцуулах.

Энэхүү асуулгын хариуг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд яаралтай горимоор танилцуулахыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН,

Д.ОЮУНХОРОЛ
З.НАРАНТУЯА
Г.ТЭМҮҮЛЭН



The image shows a red square stamp of the State Great Khural (Улсын Их Хурал) with the number 0317. Overlaid on the stamp are several handwritten signatures in black ink. To the right of the stamp, the names of the signatories are printed: Д.ОЮУНХОРОЛ, З.НАРАНТУЯА, and Г.ТЭМҮҮЛЭН. The text 'УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,' is printed to the left of the stamp.